

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР БОЛОН
ХАРЬЯА ЁС ЗҮЙН ДЭД ХОРООДЫН 2025 ОНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2026.01.13


НЭГ. Товч танилцуулга
Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам"-ын Мал эмнэлгийн ерөнхий газар болон 21 аймаг, нийслэл, УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ гэсэн 25 дэд хороо байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:
Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 86 хувьтай байна. Салбарын хэмжээнд Төрийн албаны зөвлөл болон аймгууд дахь төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан ёс зүйн холбогдолтой 27 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1256 албан хаагч хамрагдсан. Ёс зүйн дэд хороо тус бүр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журмын талаар дэд хороо бүрээс албан хаагчдад мэдээлэл сургалт хийж ёс зүйн сахилга, хариуцлагыг дэмжиж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээллээр ханган ажиллав. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд нийт 25 дэд хороо үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталсан байна. Баталсан төлөвлөгөөнүүдийг хөтөлбөрийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлттэй харьцуулан үнэлэхэд зарим төлөвлөгөө нь хэмжигдэхүйц үзүүлэлтгүй, хэрэгжилтийн хугацаа тодорхой бус, үр дүнг үнэлэгдэхүйц бус зэрэг нийтлэг дутагдал илэрсэн тул цаашид сайжруулах талаар дэд хороодод зөвлөмж өглөө.
2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан байдал 93%, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал-78%, ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал-40% биелэлттэй байна. Томилох эрх бүхий албан тушаалтнууд нь төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч ёс зүйн манлайллын түвшин жигд бус байна. Ёс зүйн бодлого, төлөвлөлт дэх манлайллын хувьд томилох эрх бүхий албан тушаалтнуудын удирдлага дор дэд хороод үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталсан нь ёс зүйн асуудлыг анхаарч байгааг илтгэж байна.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа
Мал эмнэлгийн ерөнхий газрын Ёс зүйн дэд хороо нь 2025 оны тайлант хугацаанд Мал эмнэлгийн ерөнхий газрын албан хаагчтай холбоотой ёс зүйн зөрчил гаргасан гэх 10 өргөдлийн хүрээнд нийт 9 удаа хурлыг зохион байгуулан тодруулан холбогдох мэдээллийг авч өргөдлийг шийдвэрлэн 2 гомдлын хүрээнд ёс зүйн зөрчилтэй талаарх дүгнэлт гарган томилох эрх бүхий албан тушаалтан болон холбогдогчдод хүргүүлээ. Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангуулан ёс зүйн зөрчил болон холбогдох материал, шийдвэрлэлтийг цаг тухай бүрд нь Монгол Улсын ёс зүйн хорооны "Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем" болох hnm.csc.gov.mn цахим системд бүртгэж ажилласан байна. Харьяа салбар 24 ёс зүйн дэд хорооны тайлангаас дүгнэхэд жилийн ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн байна. Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал 97% хэрэгжсэн дүнтэй бөгөөд нийт 10 гомдол, мэдээллийг шийдвэрлэн ёс зүйн зөрчилгүй 6 асуудлыг нотлох

баримтын хүрээнд тодруулан, ёс зүйн зөрчилтэй 4 асуудалд холбогдох дүгнэлтийг гарган ажилласан байна.	
Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Мал эмнэлгийн ерөнхий газар болон салбар харьяа газрууд хамт олны саналыг үндэслэн холбогдох хууль тогтоомжийн дагуу дэд хороодыг байгуулан, тогтмол үйл ажиллагаа явуулж хэвшсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийт 25 дэд хороо үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталсан байна. Ёс зүйн дэд хороодын зүгээс соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлыг дэд хороо бүр зохион байгуулж, ёс зүйн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор сургалт, уулзалт, зөвлөгөөн, мэдээлэл түгээх ажлуудыг хийж гүйцэтгэсэнээр ёс зүйн төлөвшилт, хамт олны харилцаа хандлагын хувьд эерэг нөлөө үзүүлэхэд бодитой нөлөөлөл болсон байна.	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал хангалтгүй байна. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулахад шаардагдах зардлын асуудал шийдэгдээгүй. Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг, зөрчлийн бүртгэлийн тогтолцоо жигд бус.
Цаашид шийдвэрлэх: – Үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэсний хөтөлбөрийн зорилт, шалгуур үзүүлэлттэй нийцүүлэх – Төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналын талаар дэд хороодод сургалт зохион байгуулах – Соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж, удирдах албан тушаалтны оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх – Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг бүрэн шийдвэрлэх	

00-0-00


ТАНИЛЦСАН:

ДАРГА



А.НАРАНТУЯА

ХЯНАСАН:



Ёс зүйн дэд хорооны дарга

Б.ЧУЛУУНЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН:

Тайлан гаргасан: нарийн бичгийн дарга



Х.МЭНДСҮРЭН